



# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/331

Булган

## Гэрээ шууд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авто зам дагуух газруудад хаягийн самбар байршуулах ажлыг "Би би кэй эйч" ХХК-тай 22 000 000 /хорин хоёр сая/ төгрөгөөр гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай.
2. Ажлын гүйцэтгэлд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/-д үүрэг болгосугай.
3. Дээрх ажлыг гэрээнд заасан хугацаанд холбогдох хууль, дүрэм, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Би би кэй эйч" ХХК /С.Нямдорж/-д даалгасугай.
4. Гэрээнд заасан ажлын санхүүжилтийг аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ